



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.09 № 03/30 ЧАГ/САГ/2014/ЗГМЛ

Г Зөрчил арилгуулах тухай Г

Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


- Нийт 1,942,489,582,090.36 төгрөгийн авлагаас дамжуулан зээлийн авлага 884,491,436,248.61 төгрөг, бусад авлага 21,020,078,035.78 төгрөг нийт 905,511,514,284.39 төгрөг буюу 46.6 хувийн авлага тооцоо нийлж баталгаажуулагүй, дамжуулан зээлийн авлага 1,806,829,426,068.94 төгрөгөөс 582,004,939,459.10 төгрөгийн буюу 32.2 хувийн авлага хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь “Няглан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах” гэж заасныг зөрчсөн, мөн байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулсан зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөр төлөгдөх хугацаа 4-21 жилээр хэтэрсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдо албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ Нь:

Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн авлагыг эргэн төлүүлэхэд шуурхай арга хэмжээ авч шийдвэрлэх, биелэлтийг 2014 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Б.Нямаа нарт даалгав.

АУДИТОР



Б.Сэржмядаг